АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2022.12.01 Булган аймаг

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны II хуралдааны II/04 дүгээр тогтоолоор аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2022 оны А/135 дугаар захирамжаар хэрэгжүүлэх төлөвлөгөөг шинэчлэн батлсан. Тус хөтөлбөр, төлөвлөгөөний зорилт, арга хэмжээ, зорилтот түвшнийг 2022 оны хэрэгжилттэй харьцуулан тооцож, үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3б хавсралтын дагуу гаргасан тайланд бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг тооцох аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 бүлэг, 108 зорилтын хэрэгжилтэд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд зорилтын хэрэгжилт 86.8 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.



Хүний хөгжлийн бодлогын 30 зорилт 87.3 хувь, эдийн засгийн бодлогын 23 зорилт 83.8 хувь, ногоон хөгжлийн бодлогын 25 зорилт 87.8 хувь, засаглалын бодлогын 21 зорилт 86.1 хувь, бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын 9 зорилт 89.1 хувьтай хэрэгжсэн байна. Үүнд 44 зорилт 100 хувь буюу үр дүнтэй, 50 зорилт 70.0-100 хүртэл хувь буюу тодорхой үр дүнд хүрсэн, 10 зорилт 30.0-70.0 хүртэл хувь буюу эрчимжүүлэх шаардлагатай, 2 зорилт 0-30.0 хүртэл хувь буюу үр дүнгүй байна. Харин 2 зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг 2023 оноос хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөгөөндөө тусгасан тул хэрэгжүүлж эхлэх хугацаа болоогүй гэж үзэн үнэлгээнд оруулж тооцоогүй болно.



Тус хөтөлбөрийн 5 зорилтын хэрэгжилт 0-30.0 хувийн хэрэгжилттэй байгаа ба энэхүү зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн хүрээнд бэлтгэл ажил хийгдсэн, дээд шатны байгууллагад хүсэлтээ уламжилсан боловч хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй зэргээс шалтгаалан хэрэгжилт нь удааширчээ. Үүнд:

1.1.8.Нүхэн 00-той эмнэлгийг үе шаттайгаар орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгоно.

2.2.10.Хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэлийг өмнөх оноос 2 дахин нэмэгдүүлж, хүнсний ногоо, нарийн ногооны нэр төрлийг олшруулж, сумдад өвлийн болон нарлаг хүлэмж, агуулахын аж ахуйг хөгжүүлнэ.

2.2.11.Сум дундын 500 тоннын багтаамжтай механикжсан зоорь барьж ашиглалтад оруулна.

3.2.3.“Чингийн цагаан нуур”-ын орчимд “Ус, намгархаг газрын мэдээллийн төв” байгуулж, нүүдлийн шувуу, ховор ан амьтан ажиглах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг бий болгоно.

3.4.11.Ерөнхий зориулалтын бага оврын агаарын хөлгийн байнгын нислэг бий болгоно.

Дээрх 108 зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 278 арга хэмжээнээс 157 арга хэмжээ 100 хувь, 26 арга хэмжээ 90.0 хувь, 33 арга хэмжээ 70.0 хувь, 18 арга хэмжээ 50.0 хувь, 11 арга хэмжээ 30.0 хувь, 3 арга хэмжээ 0 хувь, 1 арга хэмжээ 71.4 хувь, 1 арга хэмжээ 97.0 хувийн хэрэгжилттэй байна. Харин 3 арга хэмжээ өмнөх онд төлөвлөгдөж бүрэн хийгдсэн, 18 арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх хугацаа болоогүй, 7 арга хэмжээ Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын тогтоолоор худалдан авах ажиллагааны тендер нь цуцлагдсан болон коронавируст цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан хийгдээгүй тул үнэлгээнд оруулж тооцоогүй болно.

Энэхүү төлөвлөгөөнөөс тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангасан болон ажлын гүйцэтгэлээр нь 11 арга хэмжээг 30.0 хувиар, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй 3 арга хэмжээг 0 хувиар тус тус дүгнэлээ. Хөрөнгийн эх үүсвэргүй, холбогдох байгууллагын шийдвэр гараагүй байгаа зэрэг шалтгаанаас зарим арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байна. Үүнд:

1.1.6.3.Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг тогтвор суурьшилтай ажиллахад орон байрны дэмжлэг үзүүлэх;

1.1.8.1.Нүхэн 00-той эмнэлгийг үе шаттайгаар орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох;

1.2.1.5.“Зөв Монгол хүүхэд” хөтөлбөрийн хүрээнд хүүхэд, багачуудын зан заншил, өв уламжлал, үзэл, хандлагыг төлөвшүүлэх зорилго бүхий орон нутгийн онцлогийг тусгасан "АНХДАГЧ БУЛГАН" дунд ангийн виртуал сурах бичгийг бэлтгэн сургалтад нэвтрүүлэх;

1.2.5.3.Булган сумын 3-р сургуульд 120, Хутаг-Өндөр, Дашинчилэн, Баяннуур сум, Хялганат тосгонд тус бүр 150 ортой сургуулийн дотуур байрны барилга шинээр барих;

1.3.1.2.БТСГ-ын Б заал засвар хийх, аймгийн шигшээ багийн тамирчдын зуны сэргээлтийн бааз байгуулах;

1.4.2.1.Аймгийн Хөгжимт жүжгийн театрын шинэ барилгыг барих;

1.6.2.1.ХХҮГ-ын харьяа Сувиллын яслийн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулах;

2.2.10.2.Булган суманд 1000 м.кв бүхий өвлийн хүлэмж байгуулах;

2.2.11.1.Булган, Хутаг-Өндөр суманд тус бүр 500 тоннын багтаамжтай механикжсан зоорь барих;

2.3.5.5.Сайжруулсан түлшний үйлдвэр байгуулж, хөгжүүлэх;

3.1.1.1.Булаг шанд, Ачуут, Далын голын эхийг хашиж хамгаалах;

3.2.3.1.“Ус, намгархаг газрын мэдээллийн төв” барих;

3.4.11.1.Бага оврын агаарын хөлгийн нислэгийг тогтмолжуулах;

4.3.11.4.Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийг эмнэлгийн байртай болгох;

Тухайлбал дээрх хэрэгжилт нь удаашралтай арга хэмжээнүүдээс 11 нь төсөв хөрөнгөгүй, 3 арга хэмжээ нь удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ аваагүй, бусад байгууллагын шийдвэр гараагүй зэргээс хамаарчээ.

Гурав. Дүгнэлт

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцож, үнэлэн дараах дүгнэлтийг хийлээ.

- 2022 онд санхүүжилт нь шийдвэрлэгдсэн зорилт, арга хэмжээнүүд төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байна.
- Нийт зорилтын 87.0 хувь, арга хэмжээний 78.8 хувь нь үр дүнтэй болон тодорхой үр дүнд хүрсэн байна.
- Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойгүй болон энэ оны төсөвт тусгагдаагүйгээс шалгаалж зарим ажлууд

удааширсан байна. Тухайлбал 11 нь төсөв хөрөнгөгүй, 3 арга хэмжээ нь удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ аваагүй, бусад байгууллагын шийдвэр гараагүй зэргээс хамаарчээ.

Дөрөв. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ /Зөвлөмж/

- Хөтөлбөрийн 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг жигд ханган зохион байгуулж, явцын болон гүйцэтгэлийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, үр дүнг тооцох
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгө санхүүг жил бүрийн улс, орон нутгийн төсөвт тусгах
- Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хөрөнгө оруулалтын зарим ажлыг хориглосон тул Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, арга хэмжээнд өөрчлөлт оруулж, шинэчлэн батлуулах
- Сумын Засаг даргын Тамгын газар, хэлтэс, агентлаг, байгууллагууд үйл явцыг бус гүйцэтгэл, үр дүн, хүрсэн түвшний талаар тайлагнаж, тухайн зорилт, арга хэмжээ зорилтот түвшиндээ хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгаан нөхцөлийг тусгаж тайлагнах
- Сум, байгууллагын түвшинд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар мэдээлэл өгч, нэгдсэн ойлголтод хүрэх, харилцан уялдаатай нягт хамтран ажиллах

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС